



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт



АВТО ҮЙЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ГАЛЫН  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хяналтын байгууллага:

Шалгуулагч байгууллагын нэр:

Объектын нэр:

Байгууллагын регистрийн дугаар:

Захирлын нэр, утасны дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:

Шаардлага хангасан  
асуултын тоо



гал түймрийн онц аюултай



гал түймрийн аюултай 1 дүгээр  
зэрэглэл

Шаардлага хангаагүй  
нийт тоо



гал түймрийн аюултай 2 дугаар  
зэрэглэл



гал түймрийн аюултай 3 дугаар  
зэрэглэл



**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД**

<b>№</b>	<b>Хууль тогтоомж, стандарт, норм, нормативын зүйл, заалт</b>	<b>Асуултууд</b>	<b>Шаардлага хангасан</b>	<b>Шаардлага хангагүй</b>	<b>Төлөвлөгөөт хяналт шалгалт</b>	<b>Гүйцэтгэлийн хяналт шалгалт</b>
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.2-р зүйл	Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгасан эсэх;				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3-р зүйл	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримталсан эсэх;				
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.7-р зүйл	Барилга байгууламж, үйлдвэрийн технологид хэрэглэх бодис, материалын гал түймрийн аюулын зэрэглэлийг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулсан эсэх;				
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3-р зүйл	Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэл хөтөлсөн эсэх;				
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.5-р зүйл	Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдалд гал түймрийн аюулын үнэлгээ хийлгэсэн эсэх;				
6	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-р заалт	Тухайн барилга байгууламжид гал түймэр унтраах автомашин хүрэлцэн очих зам, талбай чөлөөлтэй эсэх;				
7	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дах заалт	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэлд техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан эсэх				
8	Галын аюулгүй	Гал түймэр унтраах шуурхай				

	<b>байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.10 дахь заалт</b>	төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх			
9	<b>Галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.7-р заалт</b>	Барилгын материал, хийц, бүтээц галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан гал тэсвэржилтийн зэргийг хангасан, итгэмжлэгдсэн лабораториос олгосон гал түймрийн аюулын ангиллын гэрчилгээтэй эсэх;			
10	<b>Галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8-р заалт</b>	Зориулалтаас хамаарч барилга нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслээр тоноглогдсон эсэх;			
11	<b>Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоол "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2-р зүйл Галын аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага</b>	2.2.1. Нутаг дэвсгэр, барилга байгууламж, өрөө тасалгаа, аврах зам, гарц;			
13		2.14. Гал унтраах автомашин явах зам, гарцыг түр хугацаагаар хаах шийдвэр гаргасан албан тушаалтан энэ талаар тухайн төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагад мэдэгдэж, зам, гарцыг хаасан хугацаанд тойрч гарах замын чиглэлийг зааж, саадыг даван гарах боломжоор хангаж, усны эх үүсвэрт хүрэх гарцыг гаргасан байна.			
15		2.17. Барилга байгууламжийг түрээслэх гэрээнд тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангах шаардлага, хариуцлагын талаар заавал тусгана.			
16		2.19. Барилга байгууламжийн аврах зам, гарцыг тухайн барилгад байрлах хүний тоог харгалзан төлөвлөж, аврах зам, гарцын өргөний хэмжээг аврах ажиллагаа явуулах хугацааны шаардлагыг хангахийц байдаар тогтооно.			
17		2.26. Түлшээр цэнэглэх халаагч, гэрэлтүүлэгч хэрэгслийг өөр төрлийн шатах шингэнээр (бензин, спирт г.м) цэнэглэхийг хориглоно.			
18		2.27. Тос, шатах шингэн болсон ажлын хувцсыг тусгайлсан газарт байрлуулсан металл шүүгээнд өлгөж хадгална.			
19		2.35.4. Зоорийн болон хагас зоорийн давхарт дүрмээр зөвшөөрөгдснөөс бусад шатамхай болон хялбар авалцан асах шингэн, дарь, тэсэрч дэлбэрэх бодис,			

		материал, хийн баллон зэрэг галын аюултай бодис, материалыг хадгалах, хэрэглэх;			
20		2.35.9. Барилгын дотор зохион байгуулалт, өрөө тасалгаа, байр байршлын өөрчлөлт хийснээр хүмүүсийг аврах үйл ажиллагаа удаашрах, гал түймэр унтраах байгаж хэрэгсэл, усан хангамжид хүрэх бололцоо хумигдах, гал унтраах автомат төхөөрөмжийн унтраах талбай багасах тохиолдолд барилгын дотоод засвар, өөрчлөлт хийх			
21	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02-ийн 7.7 дахь заалт	Зоорь ба хагас зоорийн давхарт тусгайлан авч үзсэнээс бусад нөхцөлд шатамхай хий ба шингэн мөн хялбар авалцан асах материал агуулдаг буюу хэрэглэдэг өрөө тасалгаа байрлуулахыг зөвшөөрөхгүй			
22	"Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02-ийн 6.9 дахь заалт	Авран хамгаалах ба аврах гарцын байдал холбогдох шаардлага хангасан эсэх Гарцыг дараах нөхцөлд аврах зориулалттай гэж тооцно. а) Нэгдүгээр давхрын өрөөнөөс гадагш гарах: -шууд гарах -коридор дамжиж гарах -гонх хөлийн өрөөл- оор дамжиж гарах -шатны хонгилоор дамжиж гарах -коридор ба шатны хонгилоор дамжиж гарах б) Нэгдүгээр давхраас бусад аль ч давхрын өрөөнөөс: -шатны хонгилд буюу 3-р төрлийн шатанд шууд гарах			
23	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	Тухайн барилга байгууламжид гал унтраах автомат тоног төхөөрөмж төлөвлөгдсөн эсэх,	- усны насос, усан сангийн байнгын ажиллагаа хэвийн эсэх -Удирдлагын зангилааны ажиллагаа хэвийн эсэх		
24	Гал унтраах автомат тоног төхөөрөмж, галын дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	Галын дохиоллын хэрэгсэл төлөвлөгдсөн эсэх мэдрэгч	-Утаа мэдрэгч -Дулааны -Удирдлагын самбар -гар мэдээлэгч		
25	Усан хангамж, гадна сүлжээ ба	Гал түймэр унтраах	-Гал унтраах хушуу -Галын хоолой		

	байгууламж /БНБД 40-02-16/	галын дотор болон гадна усан хангамж	-Холбох тотго -Барилгын гадна гидрант төлөвлөгдсөн эсэх			
26						
27	Агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-02/-ийн 7 дугаар зүйл	Агаарын хаялт ба утаа зайлцуулах системийн хэвийн ажиллагааг хангасан эсэх				
28	Гал түймрээс. Аж ахуй нэгж байгууллага, барилга байгууламжид зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS5566:2020 стандарт	Тухай барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл стандартын дагуу байгаа эсэх.				
29	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143 : 2013	Энэхүү стандартын холбогдох заалтуудыг хангаж байгаа эсэх				
30	Цахилгаан байгууламжийн дүрэм /БД 43-101-03/-ийн 2.1.8, 2.1.9 дэхь заалт	Тухайн барилга байгууламжийн цахилгаан шугам сүлжээний угсралт, цахилгаан тоног төхөөрөмжийн төлөвлөлт нь галын аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх,				
31		Цахилгаан утас ба кабелийн салбарлага, холболтыг шахуурга, гагнуур, гагнаас, гагнаас буюу боолтон хавчаар зэргийг ашиглан мөрдэж байгаа “Цахилгаан техникийн ажил БНБД З 05.06.90-ийн дагуу гүйцэтгэнэ. Дамжуулах утас ба кабелийн салбарлага, холболтыг хийдээ залгалтын судлыг дахин хийж болзошгүй байдлыг тооцож, нөөцтэй тайрахаас гадна үзлэг, засвар хийх боломжтой байвал зохино.				
32		Агаарын шугамын тусгаарлах шон дээр байрлах дамжуулах утаснаас бусад тохиолдолд кабель ба утасны залгаас ба салбарлагыг холболт ба салбарлагын хайрцаг, тусгаарлага бүхий корпус дахь холболтын ба				

		салбарлагын хавчаар, барилгын тусгай хийцийн нүх, цахилгаан төхөөрөмж, машин, аппаратын арьсны дотор хийж гүйцэтгэх ёстай.			
33	Авто зогсоол БНБД 21-05-10- ын Үндсэн шаардлага 5 дугаар зүйл	<p>5.3. Авто зогсоолын барилга дараах бүрдэлтэй байж болно. Үүнд: үйлчилгээний болон жижуурин ажилтанд зориулсан ажлын өрөө (хяналтын цэг болон касс, диспетчерийн өрөө, хамгаалалтын алба), техникийн зориулалтын (инженерийн тоноглолтой), ариун цэврийн өрөө, үйлчлүүлэгчдийн ачааны агуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тасалгаа түүнчлэн нийтийн утсан холбоо ба хүн зөөврийн цахилгаан шат зэрэг байна. Тэдгээрийн шаардлага, бүрэлдэхүүн хэсэг болон талбайг авто зогсоолын хэмжээ, түүнийг ашиглах онцлогоос хамааруулан зураг төслийн шатанд тогтооно.</p> <p>Хүн зөөвөрлөх цахилгаан шатны нэг бүхээг нь тэргэнцэртэй иргэд ашиглахаар тоноглогдсон байна.</p>			
		<p>5.5. Өөр зориулалттай барилгад залгаж байрлах авто зогсоол эдгээр барилга байгууламжаас галаас хамгаалах 1 дүгээр төрлийн ханаар тусгаарлагдах ёстай.</p> <p>Өөр зориулалтын барилга дотор байрлах авто зогсоол нь тухайн барилгын гал тэсвэршилтийн зэргээс багагүй байх бөгөөд бусад өрөө тасалгаа болон давхраас галаас хамгаалах 1 дүгээр төрлийн хана, хучилтаар тусгаарлагдсан байна.</p>			
		<p>5.6. Авто зогсоолын бүрдэлд авто тээврийн хэрэгслийн үйлчилгээний оношилгоо ба тохируулах ажиллагаа хийх, авто угаалга гэх мэт засвар үйлчилгээний тасалгаа төлөвлөж, шаардлагатай тохиолдолд энэ зориулалтаар тусдаа барилга, эсвэл бүлэг тасалгаа тусгах хэрэгтэй. Ийм байр нь авто зогсоолоос буюу ил зогсоол болон орон сууцны барилга дотор байрлах авто зогсоолоос бусад тохиолдолд галаас хамгаалах 2 дугаар төрлийн хана, болон 3 дугаар төрлийн хучилтаар тусгаарлагдах ёстай. Эдгээр байрны орц гарц нь автозогсоолын</p>			

		<p>орц гарцаас тусдаа байрлана. Техникийн үйлчилгээ, урсгал засварын хэсэгчилсэн засвар үйлчилгээ явуулахад шаардагдах тасалгааны бүрдэл болон талбайн хэмжээг тухайн ажлын техникийн шаардлагыг баримтлан зургийн даалгаварт тусгана.</p>			
		<p>5.8. Өөр зориулалтын барилгад байрлуулсан авто зогсоолд ердийн болон цахилгаан шатны (нэгдсэн) хонгил төлөвлөхийг хориглоно.</p>			
		<p>5.9 Худалдаа хийх зориулалтын байр, түргэн үйлчилгээний цэг, лангуу гэх мэтийг авто тээврийн хэрэгсэл байрлуулах байранд байлгахыг хориглоно.</p>			
		<p>Энэхүү дүрмийн 5.12 1 дүгээр хүснэгтэд зааснаар битүү авто зогсоолын бүх давхарт гарах рамп (пандус) нь галаас хамгаалах хаалт, том хаалга болон гал түймрийн үед утаа сорох системээр тоноглогдсон дамжих гонхоор давхар бүрдээ авто тээврийн хэрэгсэл байрлуулах байрнаас тусгаарлагдсан байх шаардлагатай. Галаас хамгаалах хаалт болон дамжих гонхонд угсарсан том жижиг хаалт, хаалга нь гал түймрийн үед автоматаар хаагдах төхөөрөмжөөр тоноглогдсон байвал зохино.</p>			
		<p>5.14.Авто зогсоолын (механикжсан авто зогсоолоос бусад тохиолдолд) гал тусгаарлах заагийн давхар тус бүрээс гадагш эсвэл шатны хонгил руу гарах 2-оос доoshгүй аврах гарц төлөвлөнө.</p>			
		<p>5.32. Хийн баллоноор ажилладаг авто тээврийн хэрэгсэл байрлуулах зориулалтын байрыг дараах газруудад байрлуулахыг хориглоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>а) авто зогсоолын цоколийн болон газар доорх давхарт;</li> <li>б) өөр зориулалттай барилгад байрлах газар дээрх битүү зогсоолд;</li> <li>в) тусгаарлагдсан рампгүй газар дээрх битүү зогсоолд;</li> <li>г) бокс бүрээс шууд гадагш гарах боломжгүй байранд авто тээврийн хэрэгслийг байрлуулах тохиолдолд.</li> </ul>			

		5.36. Газар доорх хоёр ба түүнээс олон давхар авто зогсоолд газар доорх давхрын ердийн болон цахилгаан шатны хонгилоос гарах гарцыг гал түймрээс үүсэх агаарын даралттай үед давхрын дамжих гонхоор дайрч өнгөрөхөөр төлөвлөнө.			
		5.39. 25-100 авто тээврийн хэрэгсэлд хоёр хаалга, 100-аас дээш авто тээврийн хэрэгсэлд хоёр хаалга, бүрэн ба бүрэн бус 100 авто тээврийн хэрэгсэл тутамд нэг хаалга нэмж тус тус төлөвлөнө.			
		6 дугаар зүйлийн Инженерийн ерөнхий шаардлагын 6.5-д Халаалтгүй авто зогсоол болон задгай авто зогсоолд түүний дотор механижуулсан зогсоол түүнчлэн барилгын дээвэр дээр байрлуулсан авто зогсоолын доторх гал унтраах усан хангамжийг гал сөнөөх хөдөлгөөнт техник холбогдоход зориулсан холбогч хаалтаар тоноглосон 89 (77) мм-ийн голчтой ил гаргасан патрубка бүхий хоолойгоор дамжуулахаар төлөвлөнө.			
		6.5. Газар доорх хоёр ба түүнээс олон давхар авто зогсоолын доторх галаас хамгаалах усан хангамж болон гал унтраах автомат төхөөрөмж нь гал сөнөөх хөдөлгөөнт техник холбогдоход зориулсан холбогч хаалт болон үл буцах хавхлагаар тоноглогдсон толгойтой, ил патрубкатай байна.			
		6.24. Ослын (аврах замын) гэрэлтуүлгийн сүлжээнд доорх заалтыг холбосон байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- давхар бүрийн аврах гарцанд;</li> <li>- авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний замын;</li> <li>- гал сөнөөх техник холбох зориулалтын холбогч хушуу байрлах газрын;</li> <li>- гал унтраах дотор талын кран, гал унтраагч байрлуулсан газрын;</li> <li>- гадна талын гидрант байгууламжийн нүүрэнд талд байрлуулсан цэгийн.</li> </ul>			
		6.28. Гал унтраах автоматжуулсан системийг дараахь битүү авто зогсоолын авто тээврийн хэрэгсэл хадгалах байранд төлөвлөнө. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>а) давхраас үл хамааран газар доорх авто зогсоолд;</li> </ol>			

		б) хоёр ба түүнээс олон давхартай газар дээрх зогсоолд;			
		<p>7.1. Авто зогсоолын давхар тус бүрийн гарцуудыг сайн харагдах, тод өнгийн заалтаар тэмдэглэнэ.</p> <p>Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг чиглүүлэх болон чухал ач холбогдолтой цэгүүдийг (давхруудын гарц, галын кран, гал унтраагч байрлуулсан хэсэг гэх мэт) заах тэмдэглэгээг гэрэлтдэг будаг эсвэл гийгүүлэх бурхэвчтэй хийвэл зохино.</p>			
		<p>7.2. Авто тээврийн хэрэгсэл байрлуулах байр болон рамп (пандус)-уудад тамхи татахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ тавина.</p> <p>7.3. Авто зогсоол нь галын аюулгүйн дүрэмд нийцсэн гал түймэр унтраах анхан шатны хэрэгслээр тоноглогдсон байх ёстой</p>			
		<p>7.3. Бүтээцийн ил гадаргуу дээр хийгдсэн галаас хамгаалах тусгай бурхүүл болон нэвчилгээ гэмтсэн (бүрэн болон хэсэгчилэн ажиллагаанаас гарах) тохиолдолд, дээрх хүчлага ба нэвчилгээний техникийн баримт бичигт дурьдсан ашиглалтын хугацааны дагуу тогтмол сольж эсвэл сэлбэн засварлаж байх шаардлагатай.</p>			
		<p>7.4. Тээврийн хэрэгсэл байрлуулах зарим боксыг засвар үйлчилгээний өрөө болгохоор өөрчлөн тоноглох, ашиглахыг хориглоно.</p>			
		<p>7.5. Галын аюулаас хамгаалах инженерийн системын ажиллагааг (галын кран ба гидрант, гал сөнөөх шахуургын төхөөрөмж, галын дохиолол, утаанаас хамгаалах систем, галын зарлан мэдээллэх төхөөрөмж, аврах гарцууд хаах төхөөрөмж) жилд нэгээс цөнгүй удаа шалгаж байх ёстой, үүнд улсын галын хяналтын байгууллагын төлөөллийг байлцуулан акт гаргаж баталгаажуулна.</p>			
40		7.6. Галын аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээг галын аюулгүйн дүрмийн шаардлагын дагуу авч байна.			
41	Монгол Улсын стандарт Авто зогсоол. Ангилал	5 дугаа зүйл Ил зогсоол төлөвлөх, байгуулах, ашиглахад тавигдах шаардлагыг хангаж буй эсэх;			

	ба ерөнхий шаардлага MNS 5342:2007	6 дугаар зүйл Битүү зогсоол төлөвлөх, байгуулах, ашиглахад тавигдах шаардлагыг хангаж буй эсэх;				
		7 дугаар зүйл Зогсоол эзэмшигчдэд тавих шаардлагыг хангаж буй эсэх;				
		8 дугаар зүйл Тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд тавих шаардлагыг хангаж уй эсэх;				
42	Улсын комисст хүлээн авсан эхэх					
43	Бусад					

**БАТАЛГААЖУУПАЛТ**

Хяналтын чиглэл, албан тушаалтны нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуй нэгж байгууллагын эрх бүхий албан тушаалтан
/Овог нэр/	/Овог нэр
/Гарын үсэг, тэмдэг /	/Гарын үсэг, тэмдэг/

---оо---